



II/2022


Тархаасан: 2022 оны 3 дугаар сарын 14



## Үнэмлэхүй бага температур 2022 оны 2 дугаар сард Завхан аймгийн Баянтэс суманд -46.7°C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2022 оны 2 дугаар сард Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд 9.9°C, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Баянтэс суманд -46.7°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай<sup>1</sup> харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



<sup>1</sup> - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2022 оны 2 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Өмнөговь аймгийн Ханбогд суманд 14.5 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Баянхонгор аймгийн Баянцагаан суманд 23 м/с-д хүрсэн байна.

### Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2022 оны 2 дугаар сард Баянхошуу, Амгалан, Зурагт, Толгойт, Нисэх, Богд хааны ордон музей, Таван буудал, Хайлааст, Ургах наран хороолол, Цахилгаан станц, Офицеруудын ордон, Зуун айл, 13 дугаар хороолол орчимд 0.061 мг/м<sup>3</sup>-0.487 мг/м<sup>3</sup>-д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.011 мг/м<sup>3</sup>-0.437 мг/м<sup>3</sup>-ээр буюу 22.0 хувиас 9.7 дахин их байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2022 оны 2 дугаар сард Амгалан, Зурагт, Толгойт, Нисэх, Богд хааны ордон музей, Таван буудал, Хайлааст, Ургах наран хороолол, Цахилгаан станц, Офицеруудын ордон орчимд 0.054 мг/м<sup>3</sup>-0.112 мг/м<sup>3</sup>-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.004 мг/м<sup>3</sup>-0.062 мг/м<sup>3</sup>-ээр буюу 8.0 хувиас 2.2 дахин их байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 2 дугаар сард Баянхошуу, Амгалан, Зурагт, Толгойт, Нисэх, Богд хааны ордон музей, Таван буудал, Хайлааст, Ургах наран хороолол, Цахилгаан станц, Зуун айл, 13-р хороолол, Тахилт орчимд  $0.109 \text{ мг/м}^3 - 0.485 \text{ мг/м}^3$ -д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас  $0.009 \text{ мг/м}^3 - 0.385 \text{ мг/м}^3$ -ээр буюу 9.0 хувиас 4.9 дахин их байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 10 тоосонцрын дундаж агууламж 2022 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс  $0.030 \text{ мг/м}^3$  (30.1%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс  $0.014 \text{ мг/м}^3$  (34.1%)-ээр, PM 2.5 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс  $0.015 \text{ мг/м}^3$  (23.7%)-ээр их байсан бол хүхэрлэг хийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс  $0.008 \text{ мг/м}^3$  (6.0%)-ээр бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар,  $\text{мг/м}^3$



### Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 2 сард 616 болж, өмнөх оны мөн үеэс 136 (18.1%)-аар буурсан байна. Газар хөдлөлт 2022 оны эхний 2 сард 11 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 177 (94.1 %)-гоор буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 2 сард нийт 23 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 24 (51.1%)-өөр буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 2 сард 2.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 0.2 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ<sup>2</sup>, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II	2021 I-II	2022 I-II	2022 I-II
					2021 I-II
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	509	709	752	616	81.9
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	2	9	188	11	5.9
Объектын түймрийн тоо	431	579	474	489	103.2
Амь насаа алдсан хүний тоо	17	33	47	23	48.9
Учирсан хохирол, тэрбум төгрөг	2.3	3.1	2.4	2.2	91.7
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	0.1	0.04	0.04	0.2	5.0 <sup>1</sup>

<sup>1</sup> - Дахин их

<sup>2</sup> - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

**Ойлголт, тодорхойлолт**

**Агаарын бохирдол:** Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

**Аюулт үзэгдэл:** Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

**Гамшиг:** Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

**Зөвшөөрөгдөх түвшин:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

**Хүлцэх агууламж:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



**Эх үүсвэр:**

Цаг уур, орчны шинжилгээний газар,  
Онцгой байдлын ерөнхий газар

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархах хуваарь**

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн  
газрын дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн  
газрын ахлах статистикч Б.Уянгаа  
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212